Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшинг тодорхойлсон дүн

Н.Даваажаргал[1], Д.Амарсайхан[2], М.Бүрнээ[1]

[1]АШУҮИС Био-АС, Биологийн тэнхим
[2]АШУҮИС НЭМС, Урьдчлан сэргийлэх анагаах ухааны тэнхим
Цахим шуудан: davaajargal@mnums.edu.mn, Утас: 88011788

Түлхүүр үг:
Нөхөн үржихүй
Мэдлэг
Өсвөр үе

Товч утга:
Үндэслэл: Өсвөр нас бол хүний амьдралын чухал үеүдийн нэг бөгөөд өсвөр насанд шилжиж буй охид, хөвгүүдэд бие бялдар, сэтгэл зүй, сэтгэл хөдлөл, болон зан үйлийн өөрчлөлтүүд гардаг. Иймээс өсвөр насныханд тохиолддог өөрчлөлтүүдэд дасан зохицохын тулд нөхөн үржихүй, бэлгийн боловсролын талаар хангалттай мэдлэгтэй байх шаардлагатайг судлаачид олонтаа тэмдэглэжээ. Эдгээр нь бидний судалгааны үндэслэл болсон. **Зорилго:** Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлж, түвшинг тодорхойлох. **Арга, аргачлал:** Судалгаанд УБ хотын 6 дүүрэг болон Дархан-Уул аймгийн ЕБС, МСҮТ-ийн нийт 1450 өсвөр үеийн төлөөлөл хамрагдлаа. Уг судалгаагаар өсвөр насны охид, хөвгүүдийн нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг судлахдаа сургуульд суурилсан, агшингын загварыг ашиглав. Судалгаанд оролцогчдын нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлэхдээ 30-37 оноог маш сайн, 22-29 оноог сайн, 15-21 оноог дунд, 8-14 оноог муу, 7-гоос доош оноог хангалтгүй гэж түвшингээр ангилав. Судалгааны үр дүнгийн тоон үзүүлэлтийг SPSS-25 программыг ашиглан дүн шинжилгээ хийв. **Үр дүн:** Нийт оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшин харилцан адилгүй байв. Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний 6.1-18.3 % нь маш сайн болон сайн, 29.7% нь дунд, харин 37.2% нь муу, 8.7 % нь хангалтгүй мэдлэгийн түвшинд хамаарч байна. **Дүгнэлт**: Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлсэн судалгааны дүнг нэгтгэн үзэхэд оролцогчдын дийлэнх дунд, муу мэдлэгийн түвшинд хамаарч байна. Өсвөр үеийнхний нас нэмэгдэх тусам нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн үнэлгээ сул хамааралтай (r=0.024, p=0.001)-гаар нэмэгдэж байна.

Үндэслэл: Өнөө үед дэлхийн хүн амын 22.9 хувийг өсвөр үеийнхэн эзэлж байна. 2020 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 6.6 хувь нь өсвөр үеийнхэн байгааг мэдээлсэн байна.[1]

Өсвөр үеийг 10-13 насыг эхэн үе, 14-16 насыг дунд үе, 17-19 насыг хожуу үе гэж ангилдаг. Энэ нь хүний амьдралын чухал үеүдийн нэг бөгөөд өсвөр насанд шилжиж буй охид, хөвгүүдийн бие бялдар, сэтгэл зүй, сэтгэл хөдлөл, болон зан үйлийн өөрчлөлтүүд гардаг. Хөгжиж буй орнуудад жил бүр 15-19 насны 21 сая охид жирэмслэж, тэдгээрийн 12 сая нь төрдөг гэсэн тооцоо бий[2] Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жил бүр хорин өсвөр настны нэг нь бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилдөг гэж тайлан мэдээлэлд дурдсан байна.[3] Иймээс өсвөр насны хүүхэд өсвөр насныханд тохиолддог өөрчлөлтүүдэд дасан зохицохын тулд бэлгийн боловсролын талаар хангалттай мэдлэгтэй байх шаардлагатай бөгөөд энэ нь өсвөр насныхны амьдралд бэлгийн боловсрол маш чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (2013)-аар өсвөр насны охидын жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг (62.1%), байсан төдийгүй М.Бүрнээ (2018)

нарын

ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, зан үйлийн төлөвшил хангалтгүй хэмээн үнэлсэн байна.[4,5]

Судлаач А.Энхбат (2018) нарын ЕБС-ийн ахлах ангийн сурагчид НҮЭМ-ийн талаарх өөрийн мэдлэгээ үнэлэхдээ дийлэнх буюу 82.0% нь дундаас дээш, харин 38.6% нь дадал хэвшсэн, 89% нь хандлага төлөвшсөн гэж үнэлсэн бол судалгаагаар оролцогчдын БЗДХ өвчин 34.2%, илрэх шинж тэмдэг 34.2%, халдвар дамжих замууд, ХДХВ, ДОХ-ын талаарх 26.5% мэдлэг хангалтгүй ба жирэмслэлтээс сэргийлэх арга, бэлгэвчний хэрэглээний талаарх мэдлэг мөн хангалтгүй, дадал, хандлага төлөвшөөгүй хэмээн үнэлэгдсэн байна.[6]

Цаашид өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэг тодорхойлж тэдний бэлгийн боловсролыг дээшлүүлэх, бодлого боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, тэдэнд шаардлагатай нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн чиглэлийн тусламж үйлчилгээ, мэдээллийн хэрэгцээг судлан практикт хэрэгжүүлэх нь нийгмийн тулгамдсан асуудал хэвээр байна.

Зорилго: Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлж, түвшинг тодорхойлно.

Зорилт:

1. Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлэх
2. Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг анги болон нас, хүйсийн хоорондын хамаарлыг харьцуулан судлах

Арга, аргачлал: Бидний судалгаанд УБ хотын 6 дүүрэг болон Дархан-Уул аймгийн ЕБС, МСҮТ-ийн нийт 1450 өсвөр үеийн төлөөлөл хамрагдлаа. Уг судалгаагаар өсвөр насны охид, хөвгүүдийн нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллийн хэрэгцээг судлахдаа сургуульд суурилсан, агшингын загварыг ашиглав.

Судалгааг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022/3-06-ны өдрийн хурлын шийдвэрээр ёс зүйн дүрэм, журмуудтай нийцэж байгаа тул судалгааны ажлыг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл олгосон.

Судалгаанд хамрагдагсдын нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлэхдээ 30-37 оноог маш сайн, 22-29 оноог сайн, 15-21 оноог дунд, 8-14 оноог муу, 7-гоос доош оноог хангалтгүй гэж түвшингээр ангилав.

Судалгааны үр дүнгийн тоон үзүүлэлтийг SPSS.25 программыг ашиглан дүн шинжилгээ хийв. Судалгааны өгөгдлийг хувьсагчийн төрлөөс хамааран тоон хувьсуурт үр дүнг бодит тоо, эзлэх хувь, дундаж утга, хамгийн бага, хамгийн их, голч утга, хамаарлыг корреляцийн коэффициентоор тооцлоо.


Үр дүн: Судалгаанд оролцогчдын дундаж нас 15±0.9 жил, тэдний 40.9 хувь нь эрэгтэй, 59.1 хувь нь эмэгтэй байв. Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний дийлэнх нь 63.4% X, XI ангид суралцагчид байгаа бол 25.7% нь XII ангид, 10.9% нь МСҮТ-ийн 1-р дамжаанд суралцаж байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Оролцогчдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлтүүд	Тоон утга	Эзлэх хувь (%)
Нийт	1450	100.0
Хүйс		
Эрэгтэй	593	40.9
Эмэгтэй	857	59.1
Нас (дундаж15±0.9)		
15	521	35.9
16	502	34.6
17	348	24.0
18	70	4.8
19	9	0.6
Анги		
X	479	33.0
XI	441	30.4
XII	372	25.7
МСҮТ	158	10.9

Нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэг: Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлэхдээ шилжилтийн насны онцлог, хүмүүсийн харилцаа, бэлгийн амьдралын ойлголт, өсвөр үеийнхэн ямар тохиолдолд хүсээгүй жирэмслэлтэд өртөх, үр хөндөлт болон БЗДХ-уудын талаарх агуулгын хүрээнд судаллаа.

Шилжилтийн насны охид, хөвгүүдэд ямар өөрчлөлт гардаг талаар судлан үзэхэд судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний 914 (63.0%) охидод биений юм ирэх, 890 (61.4%) хөвгүүдэд дуу хоолой бүдүүрэх, 871 (60.1%) хөх томрох, 878 (60.6%) өндөр болох, 868 (59.9%) батга гарах нь шилжилтийн насны онцлог гэж мэдэж байсан бол 58 (4.0%) мэдэхгүй гэж хариулсан байна. (Зураг 1)



Зураг 1. Шилжилтийн насны онцлогуудыг нэрлэсэн байдал

Бидний өсвөр үеийнхний БЗДХ ба ЖСАХ-ийн талаарх мэдлэгийг үнэлсэн судалгааны үр дүнгээс үзэхэд оролцогчдын дийлэнх (1217/83.9%) нь "үр хөндөлт"-н талаар тодорхой мэдлэгтэй төдийгүй өсвөр үеийнхэн "хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох" (917/63.2%) эсвэл "Мэдлэг дутмаг" (638/44.0%) байдлаас жирэмсэлж болзошгүй, мөн БЗДХ-тай хүнтэй хамгаалалтгүй бэлгийн харилцаанд орох (917/63.2%) нь халдвар тусах шалтгаан болж буйг тодорхойлж мэдэж байна.

Харин БЗДХ-тай хүнд шинж тэмдэг илрэхгүй байх боломжтой эсэхийг тодорхойлж мэдэхгүй 410 оролцогч (28.3%) хамрагдсан бол 718 (49.5%) оролцогч халдвартай хүнд шинж тэмдэг илрэхгүй байж болно хэмээн үзэж байв. Энэ нь оролцогчдын **мэдлэг** ялгаатай байгааг илэрхийлж байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. БЗДХ ба ЖСАХ-ийн талаарх мэдлэгийг тодорхойлсон дүн

Асуултууд	нийт	
	n	%
Үр хөндөлт хийлгэх нь жирэмслэлтээс сэргийлэх арга мөн үү?		
Тийм	171	11.8
Үгүй	1217	83.9
Мэдэхгүй	62	4.3
БЗДХ-ын үед илрэх шинж тэмдгийг нэрлэнэ үү?		
Хэвлийгээр өвдөх	159	11.0
Бэлэг эрхтнээс цагаан юм, идээрхэг зүйл гарах	419	28.9
Бэлэг эрхтэн загатнах	344	23.7
Шээх үед өвдөх	314	21.7
Бэлэг эрхтэн дээр яр шарх үүсэх	466	32.1
Бэлэг эрхтэн хавдах	186	12.8
Мэдэхгүй	691	47.7
БЗДХ-тай хүнд шинж тэмдэг илрэхгүй байх боломжтой юу?		
Боломжтой	718	49.5
Боломжгүй	322	22.2
мэдэхгүй	410	28.3
Өсвөр үеийнхэн хүсээгүй жирэмсэлж болзошгүй ямар тохиолдлууд байж болох вэ?		
ЖСАХ хэрэглэдэггүй	342	23.6
Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох	954	65.8
Нөхөн үржихүй,бэлгийн эрүүл мэндийн мэдлэг дутмаг	567	39.1
ЖСАХ худалдан авахаас ичдэг	385	26.6
Тоомжиргүй, хэнэггүй зан	531	36.6
Бэлгийн хавьтлын үр дагаврын талаар тунгаан боддоггүй	497	34.3
Мэдэхгүй	168	11.6

Судалгаанд оролцогчдоос "Хүмүүс хоорондын харилцааны талаарх мэдлэгийг" үнэлэхэд 1039 (71.7%) нь хүндэтгэлтэй хандах, 707 (48.8%) нь харилцааг чухалчлах, 743 (51.2%) нь үнэнч байх ба итгэлцэх, 700 (48.3%) нь бусдыг ойлгох, 140 (18.7%) нь бусдыг хүндэтгэх зэрэг нь эрүүл, эерэг харилцаа гэж үзсэн бол 130 (9.0%) нь бусдыг шүүмжлэх, гутаах доромжлох зэргээр хандах нь эрүүл бус, сөрөг харилцааны шинжүүд хэмээн хариулж байв. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Хүмүүс хоорондын харилцаа, бэлгийн амьдралын тухай мэдлэг

Асуултууд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй		P утга
	n	%	n	%	n	%	
Хүмүүс хоорондын харилцаа эрүүл байгааг илэрхийлэх шинжүүдийг сонгоно уу?							
Хүндэтгэлтэй хандах	1039	71.7	414	69.9	625	72.8	0.002*
Үнэнч байх ба итгэлцэх	743	51.2	278	47.0	466	54.3	0.045*
Харилцааг чухалчлах	707	48.8	266	44.9	441	51.4	*NS*
Бусдыг мэдэрч ойлгох	700	48.3	262	44.3	438	51.0	*NS*
Эрх мэдлээ хуваалцах	260	17.9	103	17.4	157	18.3	*NS*
Бусдын эрхэмлэх үнэт зүйлийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх	517	35.7	193	32.6	324	37.8	0.038*
Шүүмжлэлтэй хандах	130	9.0	63	10.6	67	7.8	*NS*
Гутаах, доромжлох	15	1.0	8	1.4	7	0.8	*NS*
Мэдэхгүй	153	10.6	71	12.0	82	9.6	*NS*
Хүний хөгжлийн асуудал, нийгэм соёл ба хүний эрхийн асуудлууд нь бэлгийн амьдралд хамаарагдах уу?							
Тийм	834	57.5	318	54.3	516	60.1	
Үгүй	292	20.1	136	22.7	156	18.2	0.031*
Мэдэхгүй	324	22.4	138	23	186	21.7	

***Тайлбар:** *. Статистикийн ач холбогдолтой (p<0.05)*

"Хүний хөгжлийн асуудал, нийгэм соёл ба хүний эрхийн асуудлууд нь бэлгийн амьдралд хамаарагдана" хэмээн 478 (64.0%) оролцогч үзсэн бол 104 (13.9%) энэ талаар мэдэхгүй байв. Түүнчлэн өсвөр үеийнхний 274 (36.7%) жендерт суурилсан хүчирхийллийн талаар ойлголттой байсан боловч 317 (42.4%) энэ талаар мэдэхгүй байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Бэлгийн амьдрал, хүчирхийлэлийн тухай мэдлэг

Асуултууд	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Хүний хөгжлийн асуудал, нийгэм соёл ба хүний эрхийн асуудлууд нь бэлгийн амьдралд хамаарагдах эсэх	478 (64.0%)	165 (22.1%)	104 (13.9%)
Жендерт суурилсан хүчирхийлэл мөн эсэх	274 (36.7%)	156 (20.9)	317 (42.4%)


Нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшин: Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлэхдээ шилжилтийн насны онцлог, хүмүүсийн харилцаа, бэлгийн амьдралын ойлголт, өсвөр үеийнхэн ямар тохиолдолд хүсээгүй жирэмслэлтэд өртөх, үр хөндөлт болон БЗДХ-уудын талаарх агуулгын хүрээнд судаллаа.

Нийт оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшин харилцан адилгүй байв. Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний 6.1-18.3 % нь маш сайн болон сайн, 29.7% нь дунд, харин 37.2% нь муу, 8.7 % нь хангалтгүй мэдлэгийн түвшинд хамаарч байна. Өсвөр насны охид, хөвгүүдийн дийлэнх нь нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаар муу мэдлэгтэй байгаа нь судалгааны үр дүнгээр тодорхойлогдож байна. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшин

Үзүүлэлтүүд	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	P утга
Мэдлэгийн түвшин				
Хангалтгүй	126 (8.7)	54 (9.1)	72 (8.4)	
Муу	539 (37.2)	240 (40.5)	299 (34.9)	
Дунд	431 (29.7)	177 (29.8)	254 (29.6)	0.024
Сайн	265 (18.3)	97 (16.4)	168 (19.6)	
Маш сайн	89 (6.1)	25 (4.2)	64 (7.5)	

Судалгааны дүнгээс үзэхэд оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн дундаж оноо 16.45±7.1 буюу хамгийн өндөр 30-36 оноотой 89 сурагч, 22-29 оноотой 265 сурагч, 15-21 оноотой 431 сурагч, 8-14 оноотой 539 сурагч, хамгийн бага (1-7) оноотой 126 сурагч байгаа нь тус тус тодорхойлогдлоо. (Зураг 2)



Зураг 2. Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх (мэдлэг/оноогоор)


Судалгаанд оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшинг насны бүлгээр харьцуулан судлахад 15 настай оролцогчдын мэдлэгийн дундаж оноо (SD=14.94+7.03) дунджаас доогуур, харин тэдний 212 нь муу мэдлэгийн түвшинд хамаарч байна. Харин мэдлэгийн маш сайн түвшинтэй 89 оролцогчдын ихэнх нь 15-17 насныхан байв.

Нийт оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшинг тэдний суралцаж буй ангиар авч үзвэл, XI-XII ангийнхны мэдлэг дунджаас дээгүүр, X ба МСҮТ-ийн суралцагчдын мэдлэгийн дундаж оноо бага байна. (Хүснэгт 6)

Хүснэгт 6. Оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшин (нас, ангиар)


	Мэдлэгийн түвшин					Дундаж оноо	P утга
	Хангалтгүй	Муу	Дунд	Сайн	Маш сайн		
Нас							
15	67	212	143	74	25	14.94+7.03	0.001
16	40	197	151	86	28	16.38+6.95	
17	18	113	104	86	27	18.04+7.17	
18	1	16	27	18	8	19.74+6.97	
19	0	1	6	1	1	20.44+6.08	
Нийт	126	539	431	265	89		
Анги							
X	65	202	125	68	19	14.70+6.94	0.001
XI	27	163	137	84	30	17.00+6.99	
XII	10	107	130	89	36	18.77+7.03	
МСҮТ	24	67	39	24	4	14.75+6.88	
Нийт	126	539	431	265	89		

Судалгаанд хамрагдсан өсвөр насны охидын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэг хөвгүүдээс илүү (p=0.024) байна. (Зураг 3)



Зураг 3. Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэг (хүйсээр)

Мөн оролцогчдын нас нэмэгдэхэд тэдний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн оноо шууд (p=0.001), сул (r=0.024) хамааралтайгаар нэмэгдэж байна. (Зураг 4)



Зураг 4. Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэг (насаар)

Хэлцэмж: Бид энэхүү судалгаанд УБ хотын 6 дүүрэг болон Дархан-Уул аймгийн ЕБС, МСҮТ-ийн нийт 1450 өсвөр үеийн төлөөлөл хамруулан, өсвөр үеийнхэн нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлж, түвшинг тодорхойллоо.

Бидний судалгаагаар оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн дундаж оноо 16.45±7.1 буюу хамгийн өндөр 30-36 оноотой 89 сурагч, 22-29 оноотой 265 сурагч, 15-21 оноотой 431 сурагч, 8-14 оноотой 539 сурагч, хамгийн бага (1-7) оноотой 126 сурагч байлаа.

Судалгаанд оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн түвшинг насны бүлгээр харьцуулан судлахад 15 настай оролцогчдын мэдлэгийн дундаж оноо (SD=14.94+7.03) дунджаас доогуур, харин тэдний 212 нь муу мэдлэгийн түвшинд хамаарч байна. Харин мэдлэгийн маш сайн түвшинтэй 89 оролцогчдын ихэнх нь 15-17 насныхан байв.

М.Бүрнээ (2018) нарын "Өсвөр үе, залуучуудын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагын судалгаа"-нд ЕБС-ийн ахлах ангийн 1362 сурагчид хамрагдаж, оролцогчдын БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэгийг үнэлэхэд 23 оноо авахаас дунджаар 10.3±5.3 оноо авсан ба мэдлэг 21.7-66.5% байжээ. Тэдний БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, зан үйлийн төлөвшил хангалтгүй гэж үнэлэгджээ.[5] Харин эдгээр үзүүлэлт бидний судалгаагаар мэдлэгийн түвшин дунд, муу байгаа нь ойролцоо байна.

Anwar M (2010) нар Малайзын Pulau Pinang-д 15-20 настай 1139 сурагчдын БЗДХ болон тэдний зан үйлийн тухай мэдлэгийг судалсан байна. Судалгаанд хамрагдагчдын мэдлэгийн дундаж мэдлэг оноо 11.60 ± 8.781 (авах боломжит хамгийн өндөр оноо 33) байсан ба мэдлэгийн хувь 8.7-61.5% хэмээн үнэлж, БЗДХ-ын тухай мэдлэг муу байна гэж дүгнэсэн байна[7].

Бидний судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний 80.0%, Н.Ариунтуяа (2012) нарын судалгаанд хамрагдсан МБСБ-ийн суралцагчдын 88.3% БЗДХ-тай хүнээс бэлгийн хавьтлаар халдварладаг гэдгийг мэддэг бол Linn Svensson (2013) нарын судалгаагаар Тайландын оюутнуудын 96%, Alferida Edvinsson (2011) нарын судалгаагаар Вьетнамийн ахлах сургуулийнхны 90% нь мэддэг байна. Харин бохир зүү тариураар, эхээс урагт БЗДХ дамждаг гэдгийг бидний судалгаанд оролцогчдын 25.7-45.4% мэддэг бөгөөд МСҮТ-ийн суралцагчдынхаас илүү байна.[6-8]

Харин БЗДХ нь бэлгийн хавьтлаас өөр замаар тухайлбал цус сэлбэх үед, зүү тариураар, эхээс урагт дамжиж болно гэдгийг Linn Svensson (2013), Alferida Edvinsson (2011), Н.Ариунтуяа (2012) нарын судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний мэдлэг бидний судалгаанд оролцогчдынхтой ойролцоо байна.[9-11]

БЗДХ-ын үед загатнах, яр шарх гарах зэрэг шинж тэмдгүүдийн талаар бидний судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний 21.7-32.1%, харин 2018 оны судалгаанд хамрагдсан ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын 26-29.5%, МСҮТ-ийн суралцагчдын 17.3-18.9% мэддэг байна.

БЗДХ-тай хүнд шинж тэмдэг илрэхгүй байж болох талаар бидний судалгаанд оролцогчдын 49.5%, 2018 оны судалгаагаар ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын 54.3-69.3% мэдэж байгаа нь өсвөр үеийнхэн БЗДХ-ын үе шинж тэмдэг илрэхгүй, "Нууц хугацаа" гэж байдаг тухай мэддэггүй бололтой.

2013 оны Нийгмийн үзүүлэлтийн Түүвэр судалгаа (НҮТС)-аар 15-34 насны эмэгтэйчүүдийн 97.6 хувь нь орчин үеийн ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслэлийн талаар мэддэг, 2.4 хувь нь энэ талаар огт мэдэхгүй бөгөөд тэдний 62.1 хувь нь 15-19 насны охид байгаа нь орчин үеийн өсвөр насны охидын жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг байгааг илтгэж байна.[4]

Zakaria нарын (2020) 16-18 насны өсвөр насны охидын дунд явуулсан судалгааны үр дүнгээс харахад өсвөр насны 491 (62%) охид өсвөр насанд тохиолддог бие бялдар, сэтгэл зүйн өөрчлөлтүүдийн талаар маш сайн мэдлэгтэй байсан бол 238 (30%) насанд хүрсэн өсвөр насны охид жирэмслэлтээс хамгаалах бэлдмэл хэрэглэх нь хосуудын бэлгийн харьцаанд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлдэг эсэх талаар зохих мэдлэгтэй байжээ.[8]

Siva нарын (2021) 9-12 дугаар ангийн сурагчдын дунд агшингийн судалгаа хийсэн. 346 хүүхдээс бүтэцлэн бэлтгэсэн асуулга авч, үнэлсэн. Охидын бэлгийн боловсролын талаарх мэдлэг нь хөвгүүдийнхээс мэдэгдэхүйц өндөр байсан. XII ангийн сурагчид IX ангийн сурагчдаас бэлгийн боловсролд илүү нааштай, эерэг хандлагатай байгаа нь ажиглагдсан гэжээ. Дунд сургууль д сурч байгаа өсвөр насныхны дунд бэлгийн боловсролын талаарх мэдлэг дутмаг, бэлгийн боловсролын талаар янз бүрийн байр суурь, ойлголттой байгаа нь ажиглагдаж байна.[12] Эдгээр судалгааны үр дүнгүүд нь бидний судалгааны дүнгүүдтэй ойролцоо байсан.

Ийнхүү судалгаанд оролцогчдын нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэг хангалтгүй байгаа нь БЗДХ тусах, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт зэрэг эрсдэлт хүчин зүйлд өртөх шалтгаан болж байна.

Дүгнэлт:

1. Өсвөр үеийнхний нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг үнэлсэн судалгааны дүнг нэгтгэн үзэхэд оролцогчдын дийлэнх дунд, муу мэдлэгийн түвшинд байгаа нь тодорхойлогдсон.
2. Нийт оролцогчдын анги болон мэдлэгийн түвшингийн хувьсагчид нь хоорондоо сул, статистикийн ач холбогдол бүхий хамааралтай байна. Өөрөөр хэлбэл өсвөр үеийнхний нас нэмэгдэх тусам нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийн үнэлгээ сул хамааралтай (r=0.024, p=0.001)-гаар нэмэгдэж байна.

Талархал: Судалгааны ажлыг **"**Гүүд Нэйборс" ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газраас эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн "15-19 насны өсвөр үеийнхний" нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх "Миний цэцэг шиг хүүхэд нас" төслийн баг, хамт олонд талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Монгол улсын Үндэсний Статистикийн Хороо Монгол улсын статистикийн эмхэтгэл 2020, p 51-60*
2. *DarrochJE, WoogV, BankoleA, AshfordLS, PointsK. Costs and Benefits of Meeting the Contraceptive Needs of Adolescents. Guttmacher Institute; 2016. Available from: https://www. guttmacher. org/report/adding-it-meeting-contraceptive needs-of-adolescents. [Last accessed on 2020 Dec 11].*
3. *Olasode OA. Sexual behaviour in adolescents and young people attending a sexually transmitted disease clinic, Ile Ife, Nigeria. Indian J Sex Transm Dis AIDS 2007; 28:83.*
4. *Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013. УСХ, & НҮБ. ХАС. (2014). УБ. p 124-130.*
5. *М.Бүрнээ "БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагын судалгаа (өсвөр үе, залуучуудын жишээн дээр). Боловсрол судлалын докторын зэрэг горилсон бүтээл. УБ, 2018, p 28-35.*
6. *А.Энхбат " ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дундах НҮЭМ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх нь". Бакалаврын зэрэг горилсон дипломын ажил. 2018, p 20-24.*
7. *Anwar M, Sulaiman SA, Ahmadi K, Khan TM. Awareness of school students on sexually transmitted infections (STIs) and their sexual behavior: a cross-sectional study conducted in Pulau Pinang, Malaysia. BMC Public Health. 2010 Jan 30;10:47. doi: 10.1186/1471-2458-10-47. Erratum in: BMC Public Health. 2010;10:571. PMID: 20113511; PMCID: PMC2824738.*
8. *Zakaria, Muhammad & Karim, Farzana & Mazumder, Subarna & Cheng, Feng & Xu, Junfang. (2020). Knowledge on, Attitude towards, and Practice of Sexual and Reproductive Health among Older Adolescent Girls in Bangladesh: An Institution-Based Cross-Sectional Study. International journal of environmental research and public health. 7720. 10.3390/ijerph17217720.*
9. *Svensson, Linn, & Waern, Sara.Knowledge of and attitudes to sexually transmitted diseases among Thai university students. 2013.*
10. *Ab Rahman A, Ab Rahman R, Ibrahim MI, Salleh H, Ismail SB, Ali SH, Muda WM, Ishak M, Ahmad A. Knowledge of sexual and reproductive health among adolescents attending school in Kelantan, Malaysia. Southeast Asian J Trop Med Public Health. 2011 May;42(3):717-25. PMID: 21706952.*
11. *Н. Ариунтуяа, Ч. Байгалмаа МБСБ-ийн суралцагчдын БЗДХ/ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлын өнөөгийн байдал. Тайлан, 2012. УБ. p 32-35*
12. *Siva VK, Nesan GSCQ, Jain T. Knowledge, attitude and perception of sex education among school going adolescents in urban area of Chennai, Tamil Nadu. J Family Med Prim Care. 2021 Jan;10(1):259-264. doi: 10.4103/jfmpc.jfmpc_1650_20. Epub 2021 Jan 30. PMID: 34017737; PMCID: PMC8132756.*

The result of the determination the level of knowledge about reproductive and sexual health among adolescents

Davaajargal N[1], Amarsaikhan D[2], Burnee M[1]

[1]School of Bio-Medicine, MNUMS
[2]School of Public Health, MNUMS
E-mail: davaajargal@mnums.edu.mn, Tel: +976-88011788

Background: Adolescence is one of the most important periods in a person's life, and girls and boys undergoing adolescence experience physical, psychological, emotional, and behavioral changes. Therefore, adequate knowledge of reproductive and sexuality education is necessary to adapt to the changes that occur during adolescence.
Aim: To assess and determine the level of knowledge of adolescent reproductive and sexual health.
Materials and Methods: A total of 1,450 youth representatives from 6 districts of UB city and Darkhan-Uul province EBS and MCT participated in the study. The study used a school-based, momentary model to study the knowledge of adolescent girls and boys about reproductive and sexual health. When evaluating the knowledge of reproductive and sexual health of the participants, 30-37 points were classified as very good, 22-29 points as good, 15-21 points as average, 8-14 points as poor, and less than 7 points as insufficient. Data analysis was done using SPSS.25 software.
Results: The overall level of knowledge of reproductive and sexual health among participants varied. 6.1-18.3% of the surveyed adolescents have very good and good knowledge, 29.7% have medium knowledge, 37.2% have poor knowledge, and 8.7% have insufficient knowledge.
Conclusion:

1. When summarizing the results of the study that evaluated the knowledge of reproductive and sexual health of adolescents, the majority of participants have a medium or poor level of knowledge.
2. As the age of adolescents increases, the evaluation of knowledge about reproduction and sexual health increases with a weak correlation (r=0.024, p=0.001).

Keywords: Reproduction, Knowledge, Adolescence